

“Суат” ХХК-ийн орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/05/НА-СТА-ОНА

| | |
|--|--|
| Цахим хуудас: www.audit.mn | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл |
| Өлгий хот | Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn |
| 2024 он | Аудитын менежер: Х.Женисбек |
| | Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: У.Ербол |
| | Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/05/НА-СТА-ОНА

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН “СУАТ”
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ЗАХИРАЛ Ж.АДАЛБЕК
ТАНАА

2024.03.25 № 359
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сангийн яам “Суат” ХХК-ийн 300.0 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөрийг аймгийн Орон нутгийн төсвөөс суутган төлүүлснийг богино хугацаат өглөгт шилжүүлэн бүртгэж тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 1,517.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,655.1 сая төгрөгөөр, алдагдлыг 137.2 сая төгрөг байхаар баталсан байна.

00402418

“Суат” ХХК-ийн орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

Гүйцэтгэлээр 1,668.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,760.4 сая төгрөгийн зардал гарган, 91.6 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд үүнд ямар нэгэн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|-----------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 15,047,718.59 | 24,991,339.16 |
| 1.1.2 | Дансны авлага | 161,214,667.41 | 232,143,956.27 |
| 1.1.4 | Бусад авлага | 830,000.00 | 818,500.00 |
| 1.1.6 | Бараа материал | 64,263,651.08 | 86,148,899.42 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 13,106,593.85 | 13,389,742.94 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 254,462,630.93 | 357,492,437.79 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 6,759,498,260.22 | 6,951,860,803.56 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,729,445,299.92 | 1,728,080,499.84 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 8,488,943,560.14 | 8,679,941,303.40 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 8,743,406,191.07 | 9,037,433,741.19 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 24,062,468.67 | 46,051,515.77 |
| 2.1.1.3 | Татварын өр | 192,745,344.29 | 187,194,155.10 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 17,010,935.88 | 12,594,953.21 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 33,900,871.25 | 33,900,871.25 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 331,058,656.00 | 396,586,417.66 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 598,778,276.09 | 676,327,912.99 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 660,000,000.00 | 594,472,238.34 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 660,000,000.00 | 594,472,238.34 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 1,258,778,276.09 | 1,270,800,151.33 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 4,102,142,939.17 | 4,475,758,318.17 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 4,505,765,988.90 | 4,505,765,988.90 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (1,123,281,013.09) | (1,214,890,717.21) |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 7,484,627,914.98 | 7,766,633,589.86 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 8,743,406,191.07 | 9,037,433,741.19 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 1,344,152,131.89 | 1,668,826,417.70 |
| 2 | Борлуулалтын өртөг | 1,293,493,911.89 | 1,488,552,720.91 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 50,658,220.00 | 180,273,696.79 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 244,168,200.00 | 271,883,400.91 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) | (193,509,980.00) | (91,609,704.12) |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | (193,509,980.00) | (91,609,704.12) |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (193,509,980.00) | (91,609,704.12) |
| 24 | Орлогын нийт дүн | (193,509,980.00) | (91,609,704.12) |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 0 | 0 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|---------------------------------------|------------------|-------------------------------------|--------------------|------------------|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,295,181,962.17 | 4,505,765,988.90 | (929,771,033.09) | 6,871,176,917.98 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 3,295,181,962.17 | 4,505,765,988.90 | (929,771,033.09) | 6,871,176,917.98 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) | | | (193,509,980.00) | (193,509,980.00) |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | 806,960,977.00 | | | 806,960,977.00 |
| 9 | 2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл | 4,102,142,939.17 | 4,505,765,988.90 | (1,123,281,013.09) | 7,484,627,914.98 |
| 11 | Залруулсанүлдэгдэл | 4,102,142,939.17 | 4,505,765,988.90 | (1,123,281,013.09) | 7,484,627,914.98 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | (91,609,704.12) | (91,609,704.12) |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | 373,615,379.00 | | | 373,615,379.00 |
| 17 | 2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл | 4,475,758,318.17 | 4,505,765,988.90 | (1,214,890,717.21) | 7,766,633,589.86 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---------------|--|------------------------|------------------------|
| 1 | Үндсэн үйлажиллагаанымөнгөнгүйлгээ | 1,533,556,229.71 | 1,764,488,910.68 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 1.2 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,533,556,229.71 | 1,764,488,910.68 |
| | Мөнгөнзарлагын дүн (-) | 1,484,327,101.66 | 1,717,806,937.31 |
| | Ажиллагчдад төлсөн | 503,124,857.60 | 679,213,172.45 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 163,136,534.68 | 219,603,201.00 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 52,033,762.26 | 60,937,832.62 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 262,601,557.60 | 287,925,299.19 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлдтөлсөн | 138,356,847.84 | 148,207,574.62 |
| | Татварын байгууллагад төлсөн | 201,348,102.52 | 220,996,225.24 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 5,412,825.00 | 70,500.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 158,312,614.16 | 100,853,132.19 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 34,955,124.20 | 36,738,352.80 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 2.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | | |
| 2.3 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 34,955,124.20 | 36,738,352.80 |
| | Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн | | |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 3.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | | |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 14,274,003.85 | 9,943,620.57 |

“Суат” ХХК-ийн орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

| | | | |
|---|---|---------------|---------------|
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 773,714.74 | 15,047,718.59 |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 15,047,718.59 | 24,991,339.16 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| | Үзүүлэлтүүд | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны батлагдсан төлөвлөгөө | 2023 оны гүйцэтгэл | өмнөх оноос | Төлөвлөгөөнөөс |
|------|--------------------------------------|-------------------------|--------------------------------|-------------------------|-----------------------|-----------------------|
| А | <i>Нийт орлого</i> | 1,344,152,131.89 | 1,517,968,134.80 | 1,668,826,417.70 | 324,674,285.81 | 150,858,282.90 |
| Б | <i>Нийт зардал: Үүнээс</i> | 1,537,662,111.89 | 1,655,137,783.89 | 1,760,436,121.82 | 222,774,009.93 | 105,298,337.93 |
| Б.1 | <i>Үндсэн нэмэгдэл цалин</i> | 659,285,735.96 | 790,654,681.20 | 825,336,278.21 | 166,050,542.25 | 34,681,597.01 |
| Б.2 | <i>НД,ЭМД-ын шимтгэл</i> | 89,552,131.63 | 106,738,378.75 | 113,168,221.19 | 23,616,089.56 | 6,429,842.44 |
| Б.3 | <i>УХ-ийн элэгдлийн зардал</i> | 213,503,129.18 | 213,503,129.16 | 219,355,989.00 | 5,852,859.82 | 5,852,859.84 |
| Б.4 | <i>Цахилгаан</i> | 189,130,580.48 | 189,130,580.48 | 209,672,541.08 | 20,541,960.60 | 20,541,960.60 |
| Б.5 | <i>Тээврийн зардал</i> | 2,344,700.00 | 1,600,000.00 | 1,328,000.00 | (1,016,700.00) | (272,000.00) |
| Б.6 | <i>Дулаан уур ус</i> | 34,987,576.17 | 35,095,576.17 | 36,379,258.43 | 1,391,682.26 | 1,283,682.26 |
| Б.7 | <i>Холбоо ашиглалт</i> | 5,686,757.60 | 7,584,000.00 | 8,394,334.74 | 2,707,577.14 | 810,334.74 |
| Б.8 | <i>Тули</i> | 41,066,818.19 | 41,066,818.19 | 55,366,000.00 | 14,299,181.81 | 14,299,181.81 |
| Б.9 | <i>Шатахуун</i> | 39,504,340.92 | 37,908,000.00 | 34,014,181.82 | (5,490,159.10) | (3,893,818.18) |
| Б.10 | <i>Сэлбэг хэрэгсэл</i> | 10,632,721.21 | 9,912,000.00 | 20,782,984.84 | 10,150,263.63 | 10,870,984.84 |
| Б.11 | <i>Урсгал засварын зардал</i> | 30,353,077.27 | 32,456,000.00 | 40,074,090.00 | 9,721,012.73 | 7,618,090.00 |
| Б.12 | <i>Албан томилолт</i> | 12,808,999.60 | 12,000,000.00 | 9,830,400.00 | (2,978,599.60) | (2,169,600.00) |
| Б.13 | <i>Газрын төлбөр</i> | 6,158,892.00 | 6,158,892.00 | 10,800,708.00 | 4,641,816.00 | 4,641,816.00 |
| Б.14 | <i>Хангамжийн материал</i> | 19,071,075.44 | 14,790,000.00 | 13,173,050.81 | (5,898,024.63) | (1,616,949.19) |
| Б.15 | <i>Хөдөлмөр хамгаалал</i> | 3,426,703.18 | 22,800,000.00 | 12,624,400.00 | 9,197,696.82 | (10,175,600.00) |
| Б.16 | <i>Зар сурталчилгаа</i> | 3,931,000.00 | 1,200,000.00 | 738,800.00 | (3,192,200.00) | (461,200.00) |
| Б.17 | <i>Бичиг хэргийн зардал</i> | 3,866,786.37 | 4,233,886.37 | 5,790,818.70 | 1,924,032.33 | 1,556,932.33 |
| Б.18 | <i>Сургалтын зардал</i> | 810,000.00 | 4,000,000.00 | 10,276,237.00 | 9,466,237.00 | 6,276,237.00 |
| Б.19 | <i>Төрөл бүрийн даатгал</i> | 5,051,659.09 | 5,051,659.09 | 4,122,825.00 | (928,834.09) | (928,834.09) |
| Б.20 | <i>АТБӨЯХ-ийн даатгал ,оношилгоо</i> | 541,980.00 | 541,980.00 | 772,096.00 | 230,116.00 | 230,116.00 |
| Б.21 | <i>УХХ-ийн татвар</i> | 2,831,699.48 | 2,831,702.48 | | (2,831,699.48) | (2,831,702.48) |
| Б.22 | <i>Тоног төхөөрөмж</i> | 21,564,100.00 | 25,000,000.00 | 30,759,400.00 | 9,195,300.00 | 5,759,400.00 |
| Б.23 | <i>Бусад зардал</i> | 134,060,648.12 | 81,860,500.00 | 78,937,684.73 | (55,122,963.39) | (2,922,815.27) |
| Б.24 | <i>Засвар үйлчилгээний зардал</i> | | | 5,197,272.27 | 5,197,272.27 | 5,197,272.27 |
| Б.25 | <i>ГУЗ-ын зардал</i> | 7,491,000.00 | 9,020,000.00 | 13,540,550.00 | 6,049,550.00 | 4,520,550.00 |
| | <i>+Ашиг,-алдагдал</i> | (193,509,980.00) | (137,169,649.09) | (91,609,704.12) | 101,900,275.88 | 45,559,944.97 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААҮГ, түүний үйл ажиллагаа

ОНӨААҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

“Суат” орон нутгийн өмчийн ХХК-ийн зорилго нь хэрэглэгчдийг ундны ахуйн стандартын шаардлага хангасан цэвэр усаар найдвартай хангаж, хэрэглээний явцад гарсан бохир усыг татан зайлуулж, хөнгөн шуурхай, сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Өлгий сумын хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн ундны ахуйн цэвэр усаар хангах, гарсан бохир усыг зайлуулан цэвэрлэх, нийтийн халуун усаар үйлчлэх, инженерийн байгууламжийн жигд найдвартай ажиллагааг хангах, гарсан авар ослыг богино хугацаанд арилгаж усны алдагдлыг багасгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувь орон нутгийн өмч байна.

БӨА-2024/05/НА-СТА-ОНА

3.2 ОНӨААҮГ-ын гадаад, дотоод орчин

ОНӨААҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

“Суат” ХХК нь Компанийн тухай хууль, Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Хот, суурины ус хангамж , ариутгах татуургын ашиглалтын хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг байна.

Тайлант онд Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам", 85 дугаар тогтоолоор "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам"-ыг баталсан байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 87 дугаар тогтоолоор “Суат “ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг шинэчлэн баталсан байна.

Баян-Өлгий аймгийн нийтийн ахуйн үйлчилгээний “Суат”ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Компанийн зохион байгуулалтын бүтцийн зураглал, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаар, цалингийн сан”-г шинээр баталсан байна.

Тайлант хугацаанд “Суат” ХХК -ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитор нь дотоод аудитын төлөвлөгөө боловсруулж ТУЗ-өөр батлуулаагүй, дотоод аудитын хийсэн ажлын тайлан байхгүй, өөрөөр хэлбэл компанийн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зардлын гүйцэтгэлд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, үргүй зардлыг багасгах, авлага, өр төлбөрийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг жилийн эцэст буюу 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр батлуулсан байна. Дотоод хяналтын талаар товч тайлан бичсэн боловч хангалтгүй, хэрэгжилтийг хангуулсан талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Суат” ХХК-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус компанийн захирлын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж ажилласан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Суат” ХХК-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 294.0 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|--------------------|------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 15,047.7 | 24,991.3 | 9,943.6 |
| Авлага | 162,044.7 | 232,962.5 | 70,917.8 |
| Бараа материал | 64,263.6 | 86,148.9 | 21,885.3 |
| Урьдчилж төлсөн зардал | 13,106.6 | 13,389.7 | 283.2 |
| Үндсэн хөрөнгө | 8,488,943.6 | 8,679,941.3 | 190,997.7 |
| Нийт хөрөнгө | 8,743,406.2 | 9,037,433.7 | 294,027.5 |
| Богино хугацаат өр төлбөр | 598,778.3 | 910,800.2 | 312,021.8 |
| Урт хугацаат өр төлбөр | 660,000.0 | 360,000.0 | (300,000.0) |
| Эздийн өмч | 7,484,627.9 | 7,766,633.6 | 282,005.7 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 8,743,406.2 | 9,037,433.7 | 294,027.5 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24.9 сая төгрөг болж 9.9 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс кассын үлдэгдэл 4.4 сая, арилжааны банкны үлдэгдэл 20.5 сая төгрөг байна.

Авлагын дансны үлдэгдэл 232.9 сая төгрөг болж 70.9 сая төгрөгөөр буюу 43.7 хувиар нэмэгдсэн нь айл, өрхийн авлага 26.4 сая төгрөг, төсвийн байгууллагуудаас авах авлага 40.0 сая төгрөг, бусад авлага 3.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийг насжилтаар нь авч үзвэл 225.4 сая төгрөгийн авлага нь төлөгдөх хугацаандаа байгаа, 7.5 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн найдваргүй авлага байна.

Авлага дансны үлдэгдэлд 2011 оноос хойш үүссэн, үйл ажиллагаа нь зогссон, дампуурсан аж ахуйн нэгжтэй холбоотой олон жил болсон 7.5 сая төгрөгийн авлагыг найдваргүй авлагаар бүртгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86.1 сая төгрөг болж 21.9 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материалын үлдэгдэл 22.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь “Мэйжүрмэнт” ХХК-аас ухаалаг тоолуур орлого авсантай холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 13.4 сая төгрөг нь олон жил дамжсан зардал бөгөөд эх үүсвэр нь тодорхой бус байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,679.9 сая төгрөг болж 190.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ОНХС-аас хэрэгжсэн нийт төсөвт өртөг нь 345.3 сая төгрөгийн цэвэр усны шугамын 2 ажлыг данс бүртгэлд тусгасан, аймгийн ИТХ-ын 2023 оны 149 дүгээр тогтоолоор Боловсролын газраас тус компанид балансаас баланст шилжүүлсэн 33.6 сая төгрөгийн авто машиныг орлого авснаар нэмэгдэж, тайлант оны 224.5 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 910.8 сая төгрөг болж 312.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь урт хугацаат зээлийн 300.0 сая төгрөгийн өр төлбөрийг аймгийн орон нутгийн төсвөөс суутган төлүүлснийг богино хугацаат өглөгөөр бүртгэж тайлагнасантай холбоотой байна.

Компанийн 2001 оноос хойш үүссэн урт хугацаат зээлээс тайлант онд 300.0 сая төгрөгийг суутган төлүүлсэнтэй холбоотой урт хугацаат өр төлбөрийг богино хугацаат өглөгт шилжүүлсэнтэй холбоотой дансны үлдэгдэл 312.0 сая төгрөг болж буурсан байна.

Эздийн өмчийн данс 282.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дээр дурдсан аймгийн ОНХС-аар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ болон шилжүүлэн авсан авто машинтай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

| | Үзүүлэлтүүд | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны батлагдсан төлөвлөгөө | 2023 оны гүйцэтгэл | өмнөх оноос | Төлөвлөгөөнөөс |
|------|-------------------------------|-------------------------|--------------------------------|-------------------------|-----------------------|-----------------------|
| А | Нийт орлого | 1,344,152,131.89 | 1,517,968,134.80 | 1,668,826,417.70 | 324,674,285.81 | 150,858,282.90 |
| Б | Нийт зардал: Үүнээс | 1,537,662,111.89 | 1,655,137,783.89 | 1,760,436,121.82 | 222,774,009.93 | 105,298,337.93 |
| Б.1 | Үндсэн нэмэгдэл цалин | 659,285,735.96 | 790,654,681.20 | 825,336,278.21 | 166,050,542.25 | 34,681,597.01 |
| Б.2 | НД, ЭМД-ын шимтгэл | 89,552,131.63 | 106,738,378.75 | 113,168,221.19 | 23,616,089.56 | 6,429,842.44 |
| Б.3 | ҮХ-ийн элэгдлийн зардал | 213,503,129.18 | 213,503,129.16 | 219,355,989.00 | 5,852,859.82 | 5,852,859.84 |
| Б.4 | Цахилгаан | 189,130,580.48 | 189,130,580.48 | 209,672,541.08 | 20,541,960.60 | 20,541,960.60 |
| Б.5 | Тээврийн зардал | 2,344,700.00 | 1,600,000.00 | 1,328,000.00 | (1,016,700.00) | (272,000.00) |
| Б.6 | Дулаан уур ус | 34,987,576.17 | 35,095,576.17 | 36,379,258.43 | 1,391,682.26 | 1,283,682.26 |
| Б.7 | Холбоо ашиглалт | 5,686,757.60 | 7,584,000.00 | 8,394,334.74 | 2,707,577.14 | 810,334.74 |
| Б.8 | Түлш | 41,066,818.19 | 41,066,818.19 | 55,366,000.00 | 14,299,181.81 | 14,299,181.81 |
| Б.9 | Шатахуун | 39,504,340.92 | 37,908,000.00 | 34,014,181.82 | (5,490,159.10) | (3,893,818.18) |
| Б.10 | Сэлбэг хэрэгсэл | 10,632,721.21 | 9,912,000.00 | 20,782,984.84 | 10,150,263.63 | 10,870,984.84 |
| Б.11 | Урсгал засварын зардал | 30,353,077.27 | 32,456,000.00 | 40,074,090.00 | 9,721,012.73 | 7,618,090.00 |
| Б.12 | Албан томилолт | 12,808,999.60 | 12,000,000.00 | 9,830,400.00 | (2,978,599.60) | (2,169,600.00) |
| Б.13 | Газрын төлбөр | 6,158,892.00 | 6,158,892.00 | 10,800,708.00 | 4,641,816.00 | 4,641,816.00 |
| Б.14 | Хангамжийн материал | 19,071,075.44 | 14,790,000.00 | 13,173,050.81 | (5,898,024.63) | (1,616,949.19) |
| Б.15 | Хөдөлмөр хамгаалал | 3,426,703.18 | 22,800,000.00 | 12,624,400.00 | 9,197,696.82 | (10,175,600.00) |
| Б.16 | Зар сурталчилгаа | 3,931,000.00 | 1,200,000.00 | 738,800.00 | (3,192,200.00) | (461,200.00) |
| Б.17 | Бичиг хэргийн зардал | 3,866,786.37 | 4,233,886.37 | 5,790,818.70 | 1,924,032.33 | 1,556,932.33 |
| Б.18 | Сургалтын зардал | 810,000.00 | 4,000,000.00 | 10,276,237.00 | 9,466,237.00 | 6,276,237.00 |
| Б.19 | Төрөл бүрийн даатгал | 5,051,659.09 | 5,051,659.09 | 4,122,825.00 | (928,834.09) | (928,834.09) |
| Б.20 | АТБӨЯХ-ийн даатгал, оношилгоо | 541,980.00 | 541,980.00 | 772,096.00 | 230,116.00 | 230,116.00 |
| Б.21 | ҮХХ-ийн татвар | 2,831,699.48 | 2,831,702.48 | | (2,831,699.48) | (2,831,702.48) |
| Б.22 | Тоног төхөөрөмж | 21,564,100.00 | 25,000,000.00 | 30,759,400.00 | 9,195,300.00 | 5,759,400.00 |
| Б.23 | Бусад зардал | 134,060,648.12 | 81,860,500.00 | 78,937,684.73 | (55,122,963.39) | (2,922,815.27) |
| Б.24 | Засвар үйлчилгээний зардал | | | 5,197,272.27 | 5,197,272.27 | 5,197,272.27 |
| Б.25 | ТУЗ-ын зардал | 7,491,000.00 | 9,020,000.00 | 13,540,550.00 | 6,049,550.00 | 4,520,550.00 |
| | | | | | - | - |
| | +Ашиг,-алдагдал | (193,509,980.00) | (137,169,649.09) | (91,609,704.12) | 101,900,275.88 | 45,559,944.97 |

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Суат” ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах завлалийн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дугаар тушаалаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,517.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,655.1 сая төгрөгөөр баталж, 137.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 1,668.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,760.4 сая төгрөгийн зардал гарган, 91.6 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,668.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 105.8 сая төгрөг буюу 11 хувиар давсан нь Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 87 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг шинэчлэн тогтоож нэмсэн, мөн түүнчлэн цэвэр, бохир усны шугамд холбогдсон айл, өрх 177, төсвийн байгууллага 20, аж ахуйн нэгж 31-ээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,760.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 105.3 сая төгрөг буюу 6.3 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин хөлс, нэмэгдэл болон нийгмийн даатгалын БӨА-2024/05/НА-СТА-ОНА

шимтгэлийн зардал 41.1 сая төгрөг, гэрэл цахилгааны зардал 20.5 сая төгрөг, түлш халаалтын зардал 14.3 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардал 10.8 сая төгрөг, урсгал засварын зардал 7.6 сая төгрөг, газрын төлбөр 4.6 сая төгрөг, сургалтын зардал 6.3 сая төгрөг, тоног төхөөрөмжийн зардал 5.8 сая төгрөг, засвар үйлчилгээний зардал 5.2 сая төгрөг, төлөөлөн удирдах зөвлөлийн зардал 4.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 91.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 45.6 сая төгрөгөөр бууруулж ажилласан нь цэвэр, бохир усны үйлчилгээний тариф нэмэгдсэн, цэвэр, бохир усны шугамд холбогдсон айл, өрх, аж ахуйн нэгж, төсвийн байгууллага нэмэгдсэнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Суат” орон нутгийн өмчийн ХХК -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

“Суат” орон нутгийн өмчийн ХХК -ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг “Суат” ХХК-ийн 2022 оны цэвэр хөрөнгө 7,484.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 112,3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд “Суат” ХХК-ийн цэвэр хөрөнгөнд материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор арга хэмжээ ажиллаагүй дараах зөрчил гаргасан байна. Үүнд:

Тус компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар тогтоолоор баруун бүсийн НААҮ-ний салбарын уулзалт зөвлөгөөн, спортын арга хэмжээнд 20,000.0 мянган төгрөг БӨА-2024/05/НА-СТА-ОНА

зарцуулахаар шийдвэр гаргуулж, гүйцэтгэлээр бэлэг дурсгал, шагнал, хүлээн авалтад 2,213.2 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 592.7 төгрөгийн 21 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 560.8 төгрөгийн 54 мэдээллийг оруулахаас, мэдээлэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 12.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлагыг хэрэгжүүлж, 1 зөвлөмж өгөгдсөнийг давтан шалгахад хэрэгжээгүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар өгсөн | | Биелэлт | | |
|----------|----------------------|-----|---------|-----|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |

“Суат” ХХК-ийн орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

| | | | | | |
|-----------------|----------|-----------------|----------|-----------------|------------|
| Албан шаардлага | 1 | 12,839.7 | 1 | 10,626.5 | 83% |
| Зөвлөмж | 1 | 0 | | | |
| Нийт дүн | 2 | 12,839.7 | 1 | 10,626.5 | 83% |

Албан шаардлагын хэрэгжилт 83 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэгдээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитаар эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул өмч, хөрөнгийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 152.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 152.5 сая төгрөгийн алдааг залруулсан.

Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний орлогыг 76.3 сая, мөнгөн зарлагын дүнг 76.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Аудитаар нийт 282.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 17.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 118.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 147.3 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 17.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1.“Суат” компанийн усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд хэрэглэгчдийг холбох техникийн нөхцөлөөс орох орлогыг түүвэрлэн шалгахад хавсралтад заасан нэр бүхий аж ахуйн нэгж, иргэдээс төвлөрүүлэх ёстой 14,670.0 (арван дөрвөн сая зураан зуун далан мянган) төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, данс бүртгэлд тусгаж тооцоо хийгээгүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.1-т “*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*”, 14.4.2-т “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*”, 14.4.5-т “*бүх орлого*”, 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Данс бүртгэлд тусгаагүй 14,670.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2.Тайлант оны суутган тооцох татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг түүвэрлэн шалгахад “Рахат” халуун усны үйл ажиллагаанд зориулан худалдан авсан 55,366.0 мянган төгрөгийн нүүрсний үнийг бэлтгэн нийлүүлэгч иргэний дансанд төлбөрийн баримтгүй /е-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримт/-гээр шилжүүлэн 553.6 (таван зуун тавин таван мянга зургаан зуун) төгрөгийн татварыг суутгаагүй олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-т “Хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяа татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно”, 21 дүгээр зүйлийн 21.3-т “Энэ хуулийн 15.6-д заасан орлогын дүнд 1 хувиар албан татвар ногдуулна”, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “*Үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1-т “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.5-т “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...*”, 13.7-т “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйцээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “*албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ*”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Е-баримтгүй шилжүүлсэн, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон 553.6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.Тус аймагт 2023 онд зохион байгуулагдсан баруун бүсийн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын уулзалт зөвлөгөөн, спортын арга хэмжээнд “Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар тогтоолоор 20,000.0 мянган төгрөг зарцуулахаар шийдвэр гаргуулж, гүйцэтгэлээр бэлэг дурсгал, шагнал, хүлээн авалтад 22,213.2 мянган төгрөг зарцуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд заасан хэмжээнээс 2,213.2 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх”, 4.2 дэх хэсэг “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.3-т “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*”, 15.1.5-т “*төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 118.0 ая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. “Суат” ХХК нь тайлант оны эцэст 64 аж ахуйн нэгжүүдтэй холбоотой 24,094.1 мянган төгрөгийн дансны авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна

2. Санхүүгийн тайланд он дамжин бүртгэгдсэн ажиллагсадтай холбоотой 818.5 мянган төгрөгийн авлага, 13,389.7 мянган төгрөгийн урьдчилж төлсөн зардлын тооцоо нь тодорхой бус байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1. *Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,*

санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн кассын үйл ажиллагаа, харилцах банкны гүйлгээтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: “Суат” ХХК нь тайлант онд нийтдээ 147.2 сая төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, төлбөр тооцооны гүйлгээг мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр хийсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, төлбөр тооцоог бэлэн мөнгөний кассаар дамжуулан их хэмжээний зарцуулалт хийсэн зөрчлийг цаашид арилгаж, төлбөр тооцоог зөвхөн бэлэн бусаар гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах;

2. Дотоод аудиторын үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: “Суат” ХХК-ны дотоод аудиторын төлөвлөгөөг оны эхэнд боловсруулж батлуулаагүй, компанийн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, үргүй зардлыг багасгах, авлага, өр төлбөрийг барагдуулах талаар үр дүнтэй дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, хийсэн ажлын тайлан байхгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 81, 94 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг зөрчиж байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дотоод аудиторын хийх ажлын төлөвлөгөөг оны эхэнд үндэслэлтэй боловсруулж ТУЗ-өөр батлуулах, компанийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, үргүй зардлыг багасгахад чиглэсэн дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг ТУЗ-өөр хэлэлцүүлж, зохих шийдвэр гаргуулж ажиллах;

3.1 Илрүүлэлт: Компанийн үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир усны магистраль шугамд 2023 онд холбосон байгууллагуудтай гэрээ байгуулаагүй, тооцоо судалгаагүй байна. (тайлант онд 4 байгууллагаас 14.9 сая төгрөгийн орлого оруулсан)

3.2 Өгсөн зөвлөмж: Цэвэр, бохир усны магистраль шугамд шинээр холбох айл өрх, аж ахуйн нэгжүүдийг тухай бүр бүртгэлд авч орлогыг бүрэн цуглуулж авах, гэрээ хийж баримтжуулах, үйл ажиллагааны орлого бүрдүүлэлтийг сайжруулах талаар санаачилгатай ажиллах;

“Суат” ХХК-ийн орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------|-----------------------------------|-----|--------------------------|-----------|------------|-----------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагыг дутуу тайлагнасан | 1 | 152,475.0 | | | 1 | 152,475.0 | 1 | 152,475.0 | | | | |
| Дүн | 1 | 152,475.0 | | | 1 | 152,475.0 | 1 | 152,475.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Үүнээс | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|-------------|----------|---------------|----------|-----------------|----------|--------|-----|--------------------------------------|---|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | Тоо | Дүн |
| | | | | | | | | | Албан тушаалтны тоо | | |
| Техникийн нөхцөлийн орлогыг авлагаар бүртгээгүй | 1 | 14,670.0 | 1 | 14,670.0 | | | | | | | |
| ХХОАТ суутгаагүй шилжүүлсэн | 1 | 553.6 | 1 | 553.6 | | | | | | | |
| Төрийн хэмнэлийн тухай хууль зөрчиж бэлэг дурсгал, шагнал олгосон | 1 | 2,213.2 | 1 | 2,213.2 | | | | | | | |
| Тооцоо нийлж баталгаажуул аагүй авлага | 1 | 38,302.3 | | | 1 | 38,302.3 | | | | | |

“Суат” ХХК-ийн орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудит

| | | | | | | | | | | | | |
|--|----------|------------------|----------|-----------------|----------|-----------------|----------|------------------|--|--|--|--|
| Кассаас их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ гаргасан | 1 | 147,015.4 | | | | | 1 | 147,015.4 | | | | |
| Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах | 1 | | | | | | 1 | | | | | |
| Байгууллагын орлого бүрдүүлэх талаар анхаарч ажиллах | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 7 | 202,754.5 | 3 | 17,436.8 | 1 | 38,302.3 | 3 | 147,015.4 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |